



МОНГОЛ УЛСЫН  
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ  
САЙДЫН ТУШААЛ

2003 оны 09 сарын 16 өдөр

Дугаар 302

Улаанбаатар хот

Гадаадад суралцуулах тухай

2003-2004 оны хичээлийн жилээс өндөр хөгжилтэй орны их сургуулийн магистрантур, докторантурт суралцах хүмүүсийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулсан мэргэжлийн комиссын дүгнэлт, "Өндөр хөгжилтэй орнуудад суралцагчдын асуудлаар санал, дүгнэлт гаргах комисс"-ын 2003 оны 4 дүгээр сарын 8-ны өдрийн хурлын тэмдэглэлийг үндэслэн ТУШААХ НЬ:

1.Өвгөнхүү овогтой Гэрэлтбаатарыг 2003-2004 оны хичээлийн жилээс АНУ-ын Калифорнийн Улсын Их сургуулийн магистрантурт төрийн захиргааны удирдлагын чиглэлээр 2 жилийн хугацаагаар суралцуулсугай.

2.Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны сайд, Санхүү, Эдийн засгийн сайдын 2001 оны 310/290 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан "Өндөр хөгжилтэй оронд магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам"-ын дагуу суралцагчтай гэрээ байгуулж, холбогдох төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /П.Лхагвасүрэн/, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Шинжлэх ухаан, технологи, дээд боловсролын бодлого, зохицуулалтын газар /М.Баасанжав/-т тус тус даалгасугай.

САЙД

А.ЦАНЖИД